

ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2022/214/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Хөвсгөл аймаг
2022 он

Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар
Утас: 88883317 Цахим хаяг: erdenebaatar@audit.gov.mn
Аудитын менежер: Э.Бат-Эрдэнэ
Утас: 99900662 Цахим хаяг: baterdenee@audit.gov.mn
Ахлах аудитор: Г. Эрдэнэчимэг
Утас: 99016320, Цахим хаяг: erdenechimegg@audit.gov.mn
Ньюбаланс Аудит ХХК-ийн
Захирал Б. Лхагвадорж
Утас: 99101901, Цахим хаяг: newbalance.lhagvaa@gmail.com
Чанарын хяналтын менежер Д. Гэрэлчулуун
Утас: 99509636, Цахим хаяг: d.gerlee98@gmail.com
Аудиторын туслах: Т. Мөнхгэрэл,
Утас: 99011389, Цахим хаяг: tumurmunkh08@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|--|----|
| 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 2 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| /Төгрөгөөр/..... | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 5 |
| /Төгрөгөөр/..... | 5 |
| 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 8 |
| /Төгрөгөөр/..... | 8 |
| 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 9 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 11 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 14 |
| 3. Аудитын тайлан | 15 |
| 3.1 Ерөнхий зүйл..... | 15 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт | 15 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 15 |
| 3.4 Материаллаг байдал | 16 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга | 16 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв | 17 |
| 4.1 Залруулсан алдаа..... | 19 |
| 4.4 Зөвлөмж | 19 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 19 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗДТГ | Засаг даргын Тамгын газар |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХ | Засаг даргын нөөц хөрөнгө |
| НА | Нягтлах ажил |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ИТХ | Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |

— | + 90% ▼



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120
Утас/факс: 7038 3793, Цахим илгүүдэл: khuvsgul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

ХӨВСГӨЛ АЙМГИЙН МӨРӨН СУМЫН
ЗУРГААДУГААР ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Д.БАЯРЖАРГАЛ ТАНАА

№ 2022.02.25 № 01/197
Танай _____ -ны № _____ -Т

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Мөрөн сумын Зургаадугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЗБААТАР

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | /Төгрөгөөр/ |
|------------|------------------------------------|------------------------------|------------------------------|
| | | | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | <u>89,495,053.95</u> | <u>68,435,254.76</u> |
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 00.00 | 00.00 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 00.00 | 00.00 |
| 33 | АВЛАГА | 1,000,000.00 | 00.00 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 1,000,000.00 | 00.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 88,495,053.95 | 68,435,254.76 |
| 351 | Түүхий эд материал | 2,362,500.00 | 2,399,600.00 |
| 35130 | Эм боох материал | 2,362,500.00 | 2,399,600.00 |
| 354 | Хангамжийн материал | 86,132,553.95 | 66,035,654.76 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 6,531,430.00 | 2,030,300.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 4,856,000.00 | 1,677,700.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 5,250,000.00 | 4,750,000.00 |
| 35460 | Хүнсний материал | 4,632,168.15 | 4,002,270.26 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 64,862,955.80 | 53,575,384.50 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | <u>376,195,791.11</u> | <u>387,169,449.24</u> |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 376,195,791.11 | 387,169,449.24 |
| 392 | Биет хөрөнгө | 240,579,540.95 | 251,594,449.24 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -14,685,157.44 | -22,027,736.16 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 35,162,660.00 | 45,289,243.08 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -17,404,704.00 | -11,204,630.07 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 12,630,525.00 | 17,103,500.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -6,168,601.21 | -6,351,826.21 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -2,400,000.00 | -3,000,000.00 |
| 39217 | Ном | 1,658,920.00 | 00.00 |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|------------|--|------------------------------|------------------------------|
| 393 | Биет бус хөрөнгө | 135,616,250.16 | 135,575,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -745,749.84 | -787,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | <u>465,690,845.06</u> | <u>455,604,704.00</u> |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | <u>1,249,449.00</u> | <u>00.00</u> |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 1,249,449.00 | 00.00 |
| 413 | Өглөг | 1,249,449.00 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 1,249,449.00 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | <u>464,441,396.06</u> | <u>455,604,704.00</u> |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 464,441,396.06 | 455,604,704.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | -49,499,469.94 | -58,085,162.00 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -49,499,469.94 | -49,248,469.94 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -8,836,692.06 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 218,215,444.00 | 217,964,444.00 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>465,690,845.06</u> | <u>455,604,704.00</u> |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | /Төгрөгөөр/ Тайлант оны гүйцэтгэл |
|------------|---|-----------------------|--------------------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 522,164,260.00 | 493,870,383.08 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 459,871,360.00 | 428,647,083.08 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 8,506,060.00 | 17,188,583.08 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 8,506,060.00 | 17,188,583.08 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 8,506,060.00 | 17,188,583.08 |
| 122002 | Хандив тусламж /гадаад/ | | |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 451,365,300.00 | 411,458,500.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 451,365,300.00 | 411,458,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 62,292,900.00 | 65,223,300.00 |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,350,000.00 | 2,360,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 1,461,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 350,000.00 | 899,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 60,942,900.00 | 62,862,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,942,900.00 | 62,862,500.00 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 493,555,474.87 | 501,048,155.14 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 493,555,474.87 | 501,048,155.14 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 457,718,159.04 | 498,135,558.03 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 303,805,795.24 | 323,654,085.35 |
| 210101 | Үндсэн цалин | 238,439,129.95 | 203,392,714.38 |
| 210102 | Нэмэгдэл | 35,949,124.29 | 90,033,675.62 |
| 210104 | Урамшуулал | 29,417,541.00 | 30,227,695.35 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,207,600.00 | 42,563,251.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,894,796.63 | 29,581,651.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,474,001.84 | 3,245,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,147,601.53 | 2,596,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 790,100.00 | 649,100.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,901,100.00 | 6,490,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 52,605,929.97 | 55,984,582.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,538,136.97 | 1,332,610.23 |
| 210302 | Түлш, халаалт | 43,291,027.00 | 52,682,600.72 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 7,776,766.00 | 1,969,371.59 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,761,950.00 | 41,078,401.30 |
| 210401 | Бичиг хэрэг | 2,001,000.00 | 10,753,830.00 |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|---|-----------------------------|-----------------------------|
| 210402 | Тээвэр, шатахуун | 550,000.00 | 150,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 367,500.00 | 298,200.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,360,000.00 | 835,600.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 10,483,450.00 | 16,130,700.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 00.00 | 12,910,071.30 |
| 2105 | Нормативт зардал | 25,368,586.10 | 14,885,450.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 640,000.00 | 2,010,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,728,586.10 | 12,874,950.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 748,350.00 | 1,237,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 448,350.00 | 397,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 840,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 16,219,947.73 | 18,732,187.84 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,697,604.00 | 733,582.89 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 3,413,300.00 | 3,724,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,109,043.73 | 14,274,604.95 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 35,837,315.83 | 2,912,597.11 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 00.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 00.00 | 200,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 25,170.03 | 50,617.46 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 25,170.03 | 50,617.46 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 35,812,145.80 | 2,661,979.65 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,812,145.80 | 2,661,979.65 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>28,608,785.13</u> | <u>-7,177,772.06</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 3,321,400.00 | 1,658,920.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 00.00 | 1,658,920.00 |

| | | | |
|---|--|-----------------------------|-----------------------------|
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -3,321,400.00 | -1,658,920.00 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>25,287,385.13</u> | <u>-8,836,692.06</u> |

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/Төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-----------------------|--|
| C01 | 2020 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл | 295,725,422.00 | 218,215,444.00 | -76,651,969.11 | 437,288,896.89 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 1,865,114.04 | 1,865,114.04 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 295,725,422.00 | 218,215,444.00 | -74,786,855.07 | 439,154,010.93 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 25,287,385.13 | 25,287,385.13 |
| C08 | 2020 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 295,725,422.00 | 218,215,444.00 | -49,499,469.94 | 464,441,396.06 |
| D01 | 2021 оны 1 дүгээр сарын 1-нээрх үлдэгдэл | 295,725,422.00 | 218,215,444.00 | -49,499,469.94 | 464,441,396.06 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 251,000.00 | 251,000.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 295,725,422.00 | 218,215,444.00 | -49,248,469.94 | 464,692,396.06 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -251,000.00 | 00.00 | -251,000.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -8,836,692.06 | -8,836,692.06 |
| D09 | 2021 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл | 295,725,422.00 | 217,964,444.00 | -58,085,162.00 | 455,604,704.00 |

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|------------------------------|------------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | <u>513,658,200.00</u> | <u>477,681,800.00</u> |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 451,365,300.00 | 411,458,500.00 |
| 123 | Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг | 451,365,300.00 | 411,458,500.00 |
| 123001 | Тусгай зориулалтын шилжүүлгийн орлого | 451,365,300.00 | 411,458,500.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 62,292,900.00 | 66,223,300.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 1,350,000.00 | 3,360,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,000,000.00 | 1,461,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 350,000.00 | 1,899,000.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 60,942,900.00 | 62,862,500.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 60,942,900.00 | 62,862,500.00 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | <u>504,542,200.00</u> | <u>464,181,800.00</u> |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 504,542,200.00 | 464,181,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 467,284,884.17 | 461,269,202.89 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 300,691,242.20 | 323,654,085.35 |
| 210101 | Үндсэн цалин | 235,324,576.91 | 203,392,714.38 |
| 210102 | Нэмэгдэл | 35,949,124.29 | 90,033,675.62 |
| 210104 | Урамшуулал | 29,417,541.00 | 30,227,695.35 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 42,207,600.00 | 43,812,700.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 25,894,796.63 | 30,831,100.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,474,001.84 | 3,245,400.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,147,601.53 | 2,596,300.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 790,100.00 | 649,100.00 |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|-------------|--|----------------------|---------------------|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7,901,100.00 | 6,490,800.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 57,190,429.97 | 55,284,582.54 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,538,136.97 | 1,332,610.23 |
| 210302 | Түлш, халаалт | 53,873,346.00 | 51,982,600.72 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,778,947.00 | 1,969,371.59 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 19,372,000.00 | 7,222,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 967,500.00 | 473,200.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 550,000.00 | 350,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 367,500.00 | 298,200.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 306,200.00 | 248,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 3,360,000.00 | 881,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 13,820,800.00 | 4,970,300.00 |
| 2105 | Нормативт зардал | 29,831,662.00 | 14,555,135.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,002,500.00 | 599,500.00 |
| 210502 | Хоол, хүнс | 15,884,262.00 | 12,961,635.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 10,944,900.00 | 994,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 5,277,300.00 | 7,527,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,550,000.00 | 00.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,727,300.00 | 7,527,300.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 748,350.00 | 1,237,600.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 448,350.00 | 397,600.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 300,000.00 | 840,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 11,966,300.00 | 7,975,800.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 842,000.00 | 00.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 11,124,300.00 | 7,975,800.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 37,257,315.83 | 2,912,597.11 |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | |
|--------|--|-----------------------------|------------------------------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 420,000.00 | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 420,000.00 | 200,000.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 1,025,170.03 | 50,617.46 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,025,170.03 | 50,617.46 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 35,812,145.80 | 2,661,979.65 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 35,812,145.80 | 2,661,979.65 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | <u>9,116,000.00</u> | <u>13,500,000.00</u> |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 4 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | 00.00 | 00.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 9,116,000.00 | 13,500,000.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 9,116,000.00 | 13,500,000.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 9,116,000.00 | 13,500,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 9,116,000.00 | 13,500,000.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | <u>-9,116,000.00</u> | <u>-13,500,000.00</u> |
| | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | <u>00.00</u> | <u>00.00</u> |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | | |
|-----------------------|--|-----------------------|----------------|--------------|------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 474,321,000.00 | 471,608,402.89 | 2,712,597.11 | 99.4 |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|-------------|---|----------------|----------------|--------------|-------|
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 474,321,000.00 | 471,608,402.89 | 2,712,597.11 | 99.4 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 474,321,000.00 | 471,608,402.89 | 2,712,597.11 | 99.4 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 324,538,200.00 | 323,654,085.35 | 884,114.65 | 99.7 |
| 210101 | Үндсэн цалин | 205,128,000.00 | 203,392,714.38 | 1,735,285.62 | 99.2 |
| 210102 | Нэмэгдэл | 92,301,700.00 | 90,033,675.62 | 2,268,024.38 | 97.5 |
| 210104 | Урамшуулал | 27,108,500.00 | 30,227,695.35 | 3,119,195.35 | 111.5 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 43,812,700.00 | 43,812,700.00 | 0.00 | 100.0 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 30,831,100.00 | 30,831,100.00 | 0.00 | 100.0 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,245,400.00 | 3,245,400.00 | 0.00 | 100.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,596,300.00 | 2,596,300.00 | 0.00 | 100.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 649,100.00 | 649,100.00 | 0.00 | 100.0 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,490,800.00 | 6,490,800.00 | 0.00 | 100.0 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 55,335,200.00 | 55,284,582.54 | 50,617.46 | 99.9 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,100,000.00 | 1,332,610.23 | -232,610.23 | 121.1 |
| 210302 | Түлш, халаалт | 52,135,200.00 | 51,982,600.72 | 152,599.28 | 99.7 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 2,100,000.00 | 1,969,371.59 | 130,628.41 | 93.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 5,735,200.00 | 5,735,200.00 | 0.00 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 298,200.00 | 298,200.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 300,000.00 | 300,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 298,200.00 | 298,200.00 | 0.00 | 100.0 |
| 210404 | Ном, хэвлэл | 248,500.00 | 248,500.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 4,590,300.00 | 4,590,300.00 | 0.00 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 14,665,000.00 | 13,881,135.00 | 783,865.00 | 94.7 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 599,500.00 | 599,500.00 | 0.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 13,071,500.00 | 12,287,635.00 | 783,865.00 | 94.0 |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | |
|---------------|--|----------------|----------------|--------------|-------|
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 994,000.00 | 994,000.00 | 0.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,027,300.00 | 20,027,300.00 | 0.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 7,500,000.00 | 7,500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210602 | Тавилга | 5,000,000.00 | 5,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 7,527,300.00 | 7,527,300.00 | 0.00 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 248,500.00 | 00.00 | 248,500.00 | 0.0 |
| 210702 | Дотоод албан томилолт | 248,500.00 | 00.00 | 248,500.00 | 0.0 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,237,600.00 | 1,237,600.00 | 0.00 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 397,600.00 | 397,600.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 840,000.00 | 840,000.00 | 0.00 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 8721300.00 | 7975800.00 | 745,500.00 | 91.5 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 745,500.00 | 00.00 | 745,500.00 | 0.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,975,800.00 | 7,975,800.00 | 0.00 | 100.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 474,321,000.00 | 471,608,402.89 | 2,712,597.11 | 99.4 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 62,862,500.00 | 62,811,882.54 | 50,617.46 | 99.9 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 62,862,500.00 | 62,811,882.54 | 50,617.46 | 99.9 |
| 120004 | ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 411,458,500.00 | 408,796,520.35 | 2,661,979.65 | 99.4 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 28 | 28 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 19 | 19 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8 | 8 | 0.00 | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|-------------|--|---------------------|
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| I | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,360,800.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,360,800.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,160,800.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 1,486,800.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 175,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 50,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 881,800.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 380,000.00 |
| 2105 | Нормативт зардал | 674,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 674,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 1,000,000.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,000,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 200,000.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 200,000.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,360,800.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 3,360,800.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,461,800.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 1,899,000.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I) | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг Ньюбаланс Аудит ХХК-ийн ахлах аудитор Б.Лхагвадорж, аудиторын туслах Т.Мөнхгэрэл нар гүйцэтгэж, хяналтыг Ньюбаланс Аудит ХХК-ийн аудитын чанарын хяналтын менежер Д.Гэрэлчулуун, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Г.Эрдэнэчимэг, аудитын менежер Э.Бат-Эрдэнэ, дарга, тэргүүлэх аудитор А.Эрдэнэбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Ньюбаланс Аудит” ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг нь бага насны хүүхдийг өөрийн онцлог, чадвар, бүтээлч үйлээрээ хөгжин, насан туршийн боловсролын суурь чадварыг эзэмшихэд дэмжин асрах, хамгаалах, хөгжүүлэх, сургалтын үйл ажиллагаа эрхлэх улсын төсвийн байгууллага юм.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Нийгмийн даатгалын тухай хуульд заасан шимтгэлийн хувь хэмжээнд өөрчлөлт орж, Монгол Улсын Засгийн газрын “Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай” 2021 оны 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн “Босго үнэ шинэчлэн батлах тухай” 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг өөрчилсөн, “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”-ыг хавсралтаар шинэчлэн батлах тухай Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал батлагдаж гарсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр

санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 496.9 сая төгрөгөөс 2 хувиар буюу 9.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 7.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 10.1 сая төгрөгөөр өссөн байна. Тайлант онд мөнгөн хөрөнгийн данс үлдэгдэлгүй байна.

/сая төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|----------------|-----------------|--------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Авлага | 1.0 | | -1.0 |
| Бараа материал | 88.5 | 68.4 | -20.0 |
| Биет хөрөнгө | 240.6 | 251.6 | 11.0 |
| Биет бус хөрөнгө | 135.6 | 135.6 | 0.0 |
| Нийт хөрөнгө | 465.7 | 455.6 | -10.1 |
| Дансны өглөг | 1.2 | | -1.2 |
| Засгийн газрын хувь оролцоо | 464.4 | 455.6 | -8.8 |
| Хуримтлагдсан үр дүн | -49.5 | -58.1 | -8.6 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 465.7 | 455.6 | -10.1 |

Авлага, өглөгийн дансны үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 68.4 сая төгрөг болж, 20.0 сая төгрөгөөр буурсан нь бусад хангамжийн материалын нөөц 11.3 сая төгрөгөөр, бичиг хэрэг, аж ахуйн материалын үлдэгдэл 7.7 сая төгрөгөөр буурсантай холбоотой байна.

Биет хөрөнгийн дүн 251.6 сая төгрөг болж, 11.0 сая төгрөгөөр өссөн нь тайлант хугацаанд сургалтын тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл худалдан авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо данс 455.6 сая төгрөг, хуримтлагдсан үр дүн -58.1 сая төгрөг, Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл 218.0 сая төгрөг байна.

Тус байгууллагын 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 493.9 сая төгрөг, нийт зардал 501.0 сая төгрөг тайлант үеийн үр дүн -7.1 сая төгрөг байна.

Өмчийн өөрчлөлтийн тайланд тайлант хугацааны үр дүн -8.8 сая төгрөгөөр нөлөөлж, нийт цэвэр өмчийн дүн 455.6 сая төгрөг байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны төсвийн төслийг 716.3 сая төгрөгөөр тооцон төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна. Тайлант онд 534.2 сая төгрөгөөр анх баталж, 59.9 сая төгрөгөөр төсвийн тодотгол хийж, 474.3 сая төгрөгийн төсөв баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг нь 2021 онд 474.3 сая төгрөг батлагдсанаас 474.3 сая төгрөгийн урсгал санхүүжилт авч, нийт 474.3 сая төгрөгийн санхүүжих эх үүсвэрээс 471.6 сая төгрөгийг урсгал зардалд зарцуулж, 2.7 сая төгрөг хэмнэж, улсын болон орон нутгийн төсөвт 2.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар нийт 3.4 сая төгрөг хүлээн авснаас 1.0 сая төгрөг өмнөх оны татаас санхүүжилтийн авлага, үндсэн үйл ажиллагааны орлого 2.2 сая төгрөг, нэг удаагийн шагнал, урамшуулалд 0.02 сая төгрөгийг (аймгийн Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны 12 дугаар сарын 3-ны өдрийн А/145 дугаар тушаалын дагуу “Эрүүл мэндийг дэмжигч байгууллага” шагнал) тус тус хүлээн авч, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгалын зардалд 0.9 сая төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 0.4 сая төгрөг, гал тогооны багаж, техник, хэрэгсэл худалдан авахад 1.0 сая төгрөгийг зориулалтын дагуу зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайланд тусгагдаагүй онцлог үйл ажиллагааг харуулбал:

Үүнд: Коронавирус-2019 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэхэд байгууллагын тасралтгүй үйл ажиллагааг хангах, орон нутагт малын гоц халдварт өвчинтэй тэмцэх гэх мэт үйл ажиллагаа нь онцлог асуудал байна.

Үүнээс үүдэн сургуулийн өмнөх боловсролын байгууллагын үйл ажиллагаа хэвийн бус явагдаж, өдөрт хамран суралцах хүүхдийн тоо төлөвлөсөн 240-өөс буурч, хамгийн ихдээ 70 хүүхэд хамрагдсан нь хоол, хүнсний зардлыг төсвийн тодотголоор бууруулан батлах үндэслэл болсон байна. Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл болох гүйцэтгэлийн төлөвлөгөөний тайлан, худалдан авах ажиллагааны тайлан нь санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

3.8 Аудитын гол асуудал

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлангийн гол нөлөө бүхий асуудал нь оны эхний хагас жилд тус байгууллага Засгийн газраас баримталсан төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээг хэрэгжүүлж, 59.9 сая төгрөгийг зарцуулаагүй учир тайлант хугацаанд төсвийн тодотголоор төсвийг бууруулан баталсан.

Энэхүү зарцуулагдаагүй зардалд үндсэн цалингийн зардлын 5.5 сая төгрөг, хоол, хүнсний зардлын 54.4 сая төгрөг багтсан.

Дээр дурдсан төсвийн тодотголыг 2021 оны 7 дугаар сарын 7-ны өдөр батлагдсан Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, Хөвсгөл аймгийн ИТХ-ын 2021 оны 8 дугаар сарын 20-ны өдрийн "Аймгийн 2021 оны төсөвт тодотгол хийх тухай" 01 дүгээр тогтоолоор баталсан.

Тайлант онд төсвийн зохицуулалтыг Мөрөн сумын ИТХ-ын 2021 оны 9 дүгээр сарын 24-ний өдрийн "Сумын 2021 оны төсөвт тодотгол оруулах тухай" 2 дугаар тогтоол, Засаг даргын 2021 оны 12 дугаар сарын 07-ны өдрийн "Төсөвт зохицуулалт хийх тухай" А/608 дугаар захирамжаар нийт 2 удаа хийсэн.

Тайлант жилийн онцгой нөхцөл байдлаас үүдэн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 6.2 сая төгрөг, хоол хүнсний зардлаас 27.0 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 6.8 сая төгрөгийг шилжүүлэн, урсгал засварын зардалд 1.8 сая төгрөг, бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлсийн зардалд 3.0 сая төгрөг, эм бэлтгэхэд 0.5 сая төгрөг, аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардалд 0.5 сая төгрөг, хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх зардалд 1.0 сая төгрөг, багаж, техник хэрэгсэл худалдан авах зардалд 7.5 сая төгрөг, хүүхдийн хувцасны 3 хаалгатай шүүгээ худалдан авахад 1.9 сая төгрөг, номын шүүгээ худалдан авахад 1.2 сая төгрөг, багш нарын сургалтын өрөөний буйдан, номын шүүгээ худалдан авахад 1.9 сая төгрөгийг тус тус зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарыг тус тус баримтлан ажилласан байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан.

Байгууллагын 2021 оны санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийн асуудлыг авч үзсэн бөгөөд аудитын санал дүгнэлтэд хамруулан үзээгүй болно.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 249.4 сая төгрөгийн 65 мэдээллээс 159.5 сая төгрөгийн 50 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 89.9 сая төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим захиргааны хэм хэмжээний актын нийцлийн хэрэгжилтийг хянан үзлээ. Үүнд: Засгийн газрын 2021 оны 2 дугаар сарын 17-ны өдрийн "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоол, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн "Босго үнэ шинэчлэн батлах тухай" 124 дүгээр тогтоолын хавсралт ёсоор баталсан шууд худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаарт тус тус нийцсэн эсэхийг дүгнэн үзсэн болно.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалын дансны бүртгэл, нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 2 зөвлөмж өгснийг аудитаар дахин хянахад 1 зөвлөмж хэрэгжиж, 1 зөвлөмж хэрэгжээгүй байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байгууллага нь 2013 онд бараа материалын дансанд бүртгэн авсан 5.3 сая төгрөгийн барилгын зураг төсвийг цаашид хэрхэх асуудлыг шийдвэрлэсэн байдлыг анхаарах, мөн дээд шатны төсвийн захирагч нарын 2021 онд төсвийг зохицуулан шийдвэрлэсэн шийдвэрийн нийцлийг авч үзэх нь зүйтэй юм.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй бөгөөд Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлэхтэй холбоотой зөрчил илэрсэн.

4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотой алдаа илрээгүй тул залруулсан алдаагүй болно.

4.2 Төлбөрийн акт

Төлбөрийн акт тогтоогоогүй болно.

4.3 Албан шаардлага

Албан шаардлага өгөөгүй болно.

4.4 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шилэн дансны мэдээлэлтэй холбоотой асуудлаар

- 1.1. Илрүүлэлт: Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн нийцлийг авч үзэхэд www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээлбэл зохих 249.4 сая төгрөгийн 65 мэдээллээс 159.5 сая төгрөгийн 50 мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлж, 89.9 сая төгрөгийн 15 мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.
- 1.2. Өгсөн зөвлөмж: Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ.” Заалтыг хэрэгжүүлж, мэдээллийг хугацаанд нь, үнэн зөв мэдээлж хэвших.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 8 дугаар сарын 19 -ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|-----|-----------|-----|---------------|-----|-----------------|-----|---------|-----|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэгийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

| | | | | | | | | | | | |
|---|--|----|------|--|--|--|--|--|--|----|------|
| 1 | Мөрөн сумын Хүүхдийн 6 дугаар цэцэрлэг | 15 | 89.9 | | | | | | | 15 | 89.9 |
|---|--|----|------|--|--|--|--|--|--|----|------|

